

ҮСХ-ны дарга, Сангийн сайд болон ГЕГ-ын даргын 2009  
оны 02-р сарын 17-ны өдрийн 01/17/ 42/ 069 тоот хамтарсан  
тушаалын хавсралт

# **Гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал**

**Улаанбаатар хот  
2009 он**

# **МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БАРААНЫ СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ**

## **I. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Гадаад худалдааны барааны нийт эргэлт, экспорт, импортын хэмжээ, тэнцэл, худалдааны индексийг тооцоход энэхүү аргачлалын зорилго оршино.
- 1.2. Үндэсний тооцооны систем-93 болон төлбөрийн тэнцлийг зохиох гарын авлага /5 дахь хэвлэл/-тай уялдуулан 1998 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан “Олон улсын барааны худалдааны ойлголт, тодорхойлолт” зөвлөмж болон “Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай конвенц” /Киотогийн конвенц-/ид нийцүүлэн энэхүү аргачлалыг боловсруулав.
- 1.3. Улс орны эдийн засгийн нутаг дэвсгэрт материаллаг нөөцийг нэмэгдүүлэн хилийн чанадаас оруулж байгаа барааг импортод; материаллаг нөөцөөс хилийн чанадад гаргаж байгаа барааг экспортод бүртгэнэ.
- 1.4. Экспорт, импортод хамаарах барааны урсгалыг гаалийн бүрдүүлэлтийн горимыг ашиглан тогтооно.

## **II. Ойлголт, тодорхойлолт**

Гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцоход ашиглах нэр томъёог дараахь байдлаар ойлгоно.

- 2.1. “Эдийн засгийн нутаг дэвсгэр” гэж засаг захиргааны хувьд Монгол улсад харьялагдах:
  - 2.1.1. хүн ам чөлөөтэй зорчиж, бараагаа гүйлгээнд оруулж, хөрөнгөө байршуулах газар зүйн нутаг дэвсгэрийг;
  - 2.1.2. гадаад орны засгийн газартай тохирч өөрийн орны дипломат төлөөлөгчийн газар, эрдэм шинжилгээний болон бусад байгууллагыг байрлуулахаар эзэмшсэн буюу түрээслэсэн газар нутгийг;
  - 2.1.3. гадаад далай дахь тухайн орны мэдлийн хэсэг болон агаарын орон зайлгах;
  - 2.1.4. гаалийн хяналтад байгаа аливаа чөлөөт бүс, үйлдвэрийн газар, агуулахыг хэлнэ.
- 2.2. “Эдийн засгийн харьяат” гэж дараахь ангилалд хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг хэлнэ. Үүнд:

- 2.2.1. Монгол улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж байгаа Монгол улсын иргэд;
  - 2.2.2. Гадаад орнуудад 183 хоног хүртэл хугацаагаар түр оршин сууж байгаа Монгол улсын иргэд;
  - 2.2.3. Монгол улсын нутаг дэвсгэр дээр 183 хоногоос дээш хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэд;
  - 2.2.4. Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар;
  - 2.2.5. Монгол улсаас гадаад оронд суугаа элчин сайдын яам, консулын болон байнгын төлөөлөгчдийн газар, тэдгээрт ажилладаг Монгол улсын иргэд, цэргийн албан хаагч, гэр бүлийн гишүүдийн хамт;
  - 2.2.6. Гадаад оронд сурч байгаа болон гадаадад урт болон богино хугацаагаар эмчлүүлж буй Монгол улсын иргэд.
- 2.3. "Эдийн засгийн харъяат бус" гэдэгт 2.2-т үл хамрагдах гадаад орны болон Монгол улсын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг;
  - 2.4. "Гаалийн нутаг дэвсгэр" гэж Монгол улсын гаалийн хууль тогтоомж үйлчилж буй нутаг дэвсгэрийг;
  - 2.5. "Чөлөөт бус" гэж гаалийн болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдох, хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол улсын нутаг дэвсгэрийн хэсгийг;
  - 2.6. "Бараа" гэж өмчлөх эрх бүхий эсвэл өмчлөх эрх нь нэгээс нөгөөд шилжиж болдог, эрэлт хэрэгцээтэй материаллаг эд зүйлийг;
  - 2.7. "Монголын бараа" гэж гаалийн нутаг дэвсгэрт боловсруулалт хийснээс бусад Монгол улсад үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, эсхүл Монгол улсын нутаг дэвсгэр дээр чөлөөт эргэлтэд байгаа гадаадад үйлдвэрлэсэн барааг;
  - 2.8. "Гадаадын бараа" гэж 2.7-д зааснаас бусад барааг;
  - 2.9. "Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусlamжийн бараа" гэж давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшигийн улмаас учирсан хохирлыг арилгахад зориулсан, түүнчлэн Монгол улсын засгийн газраас гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагатай байгуулсан гэрээний дагуу болон олон улсын хүмүүнлэгийн тусlamжийн байгууллагаас хариу төлбөргүйгээр хүлээн авсан барааг;

- 2.10. “мөнгөжсөн алт” гэж үндэсний болон олон улсын мөнгө, санхүүгийн байгууллага, эрх бүхий банк хооронд солилцож буй алтыг;
- 2.11. “мөнгөжөөгүй алт” гэж нунтаг болон бусад хэлбэртэй боловсруулаагүй эсхүл хагас боловсруулсан алт, алтан зоос, гулдмай зэрэг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагдах, үнэ цэнээ алдахгүй хадгалагдах алтыг;
- 2.12. “гүйлгээнд ороогүй мөнгөн тэмдэгт, зоос” гэж гүйлгээнд оруулах зорилгоор Монголбанкнаас гадаад оронд хэвлүүлэн улсын хилээр оруулж байгаа үндэсний мөнгөн тэмдэгтийн /төгрөгийн/ шинэ дэвсгэрт, зоосыг;
- 2.13. “үнэт цаас” гэж Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компанийн бүх төрлийн хувьцаа, компанийн гаргасан, эсхүл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн бичиг /опцион/, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос “Үнэт цаасны зах зээлийн тухай” Монгол улсын хуульд нийцүүлэн үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг;
- 2.14. “гүйлгээнд ороогүй үнэт цаас” гэж гүйлгээнд оруулах зорилгоор захиалагчаас гадаад оронд хэвлүүлсэн үнэт цаасыг;
- 2.15. Гаалийн нутаг дэвсгэрт барааг үйлдвэрлэлийн аргаар боловсруулахад дараахь үйл ажиллагаа хамаарна:
  - 2.15.1. боловсруулах, эсхүл баяжуулах;
  - 2.15.2. бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
  - 2.15.3. бараанд засвар хийх;
  - 2.15.4. барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах.

### **III. Гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцох арга, мэдээллийн эх үүсвэр**

- 3.1. Гадаад худалдааны барааны статистикийн дараахь үзүүлэлтийг тооцож, гаргана. Үүнд:
  - 3.1.1. Нийт экспорт. Гаалийн экспортын мэдүүлгийн “статистик дүн” гэсэн мөрийн нийлбэрээр нийт экспортын хэмжээг тодорхойлно.
  - 3.1.2. Нийт импорт. Гаалийн импортын мэдүүлгийн “статистик дүн” гэсэн мөрийн нийлбэрээр нийт импортын хэмжээг тодорхойлно.
  - 3.1.3. Нийт бараа эргэлт. Гадаад худалдааны нийт барааны эргэлтийг нийт экспорт, импортын нийлбэрээр тодорхойлно.

- 3.1.4. Валютын төлбөртэй бараа. Гаалийн мэдүүлэгт “валютын төлбөртэй” хэлцлийн кодоор ангилагдсан барааны “статистик дүн” гэсэн мөрийн нийлбэрээр тооцно.
- 3.1.5. Бараа солилцоо. Гаалийн мэдүүлэгт “бараа солилцоо” хэлцлийн кодоор ангилагдсан барааны “статистик дүн” гэсэн мөрийн нийлбэрээр тооцно.
- 3.1.6. Боловсруулах бараа. Гаалийн мэдүүлэгт “боловсруулах эсхүл баяжуулах”, “шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх”, “өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах” хэлцлийн кодоор ангилагдсан барааны “статистик дүн” гэсэн мөрийн нийлбэрээр тооцно.
- 3.1.7. Гадаадын тусlamжийн бараа. Гаалийн импортын мэдүүлэгт “буцалтгүй тусlamжийн бараа”, “хүмүүнлэгийн тусlamжийн бараа” хэлцлийн кодоор ангилагдсан барааны “статистик дүн” гэсэн мөрийн нийлбэрээр тооцно.
- 3.1.8. Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа. Гаалийн импортын мэдүүлэгт “хөрөнгө оруулалтын бараа” хэлцлийн кодоор ангилагдсан барааны “статистик дүн” гэсэн мөрийн нийлбэрээр тооцно.
- 3.1.9. Гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа. Гаалийн импортын мэдүүлэгт “засгийн газрын шугамаар авсан зээлийн бараа”, “засгийн газрын бус шугамаар авсан зээлийн бараа” хэлцлийн кодоор ангилагдсан барааны “статистик дүн” гэсэн мөрийн нийлбэрээр тооцно.
- 3.1.10. Тэнцэл. Нийт экспортоос импортыг хассан зөрүүгээр тэнцлийг тодорхойлно. Тэнцэл (-) тэмдэгтэй бол алдагдалтай, (+) тэмдэгтэй бол ашигтай гэж үзнэ.
- 3.1.11. Экспорт, орноор. Гаалийн экспортын мэдүүлэгт “хүлээн авагч улс”-ын кодоор ангилагдсан барааны “статистик дүн” гэсэн мөрийн нийлбэрээр улс тус бүрээр гаргана.
- 3.1.12. Импорт, орноор. Гаалийн импортын мэдүүлэгт “гарал үүслийн улс”-ын кодоор ангилагдсан барааны “статистик дүн” гэсэн мөрийн нийлбэрээр улс тус бүрээр гаргана.
- 3.1.13. Экспорт, импорт, барааны нэр төрлөөр. Гаалийн мэдүүлгийн “Барааны код”-оор ангилж, “Ангилалтаар тоо хэмжээ” болон “Статистик дүн” гэсэн мөрийн нийлбэрээр тооцож, тоо хэмжээ болон үнийн дүнгээр гаргана.
- 3.1.14. Худалдааны унийн болон биет хэмжээний ерөнхий индекс.

Худалдааны үнийн болон биет хэмжээний ерөнхий индексийг тооцоход “Гадаад худалдааны үнийн болон биет хэмжээний индекс тооцох аргачлал”-ыг баримтлана.

Экспорт, импортын үнийн ерөнхий индексийг (1) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$$PIL = \frac{\sum p_{nt} w_{no}}{\sum p_{no} w_{no}} \quad \text{буюу} \quad PIL = \frac{\sum p_i w_{no}}{\sum w_{no}} \quad (1)$$

$PIL$  - үнийн ерөнхий индекс, Ласпейрес гэсэн англи хэллэгийн эхний үсэг

$n$  – барааны нэр төрөл

$t$  – тайлант үе

$i$  – индекс

$o$  – суурь үнэ

$P_{nt}$  -  $n$  нэр төрлийн барааны тайлант үеийн үнэ

$P_{no}$  -  $n$  нэр төрлийн барааны суурь үнэ,

$P_i$  - барааны хувийн индекс

$W_{no}$  - Экспорт, импортын нийт дүнд  $n$  нэр төрлийн барааны үнэ тус бүрийн эзлэх хувь, суурь үнээр

Экспорт, импортын биет хэмжээний ерөнхий индексийг (2) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$$QIP = \frac{\sum p_{no} q_{nt}}{\sum p_{no} q_{no}} \quad (2)$$

$QIP$ - биет хэмжээний индекс, Пааше гэсэн англи хэллэгийн эхний үсэг

$P_{no}$  -  $n$  нэр төрлийн барааны суурь үнэ

$Q_{nt}$  -  $n$  нэр төрлийн барааны тайлант үеийн биет хэмжээ

$Q_{no}$  -  $n$  нэр төрлийн барааны биет хэмжээ, суурь үнээр

- 3.1.15. Худалдааны нөхцөлийн коэффициент. Экспортын үнийн ерөнхий индексийг импортын үнийн ерөнхий индекст харьцуулж энэхүү коэффициентийг гаргана.
- 3.2. Энэхүү аргачлалын 3.1.1 - 3.1.13 дугаар үзүүлэлтийг сар бүр, 3.1.14 - 3.1.15 дугаар үзүүлэлтийг хагас, бүтэн жилээр гаргана.
- 3.3. Уг аргачлалын 3.1.1, 3.1.2 дугаар үзүүлэлт болон 3.1.13 дугаар үзүүлэлтийг гол нэр төрлийн бараагаар, сард 4 хүртэлх давтамжтайгаар гаргана.

- 3.4. Мэдээллийн эх үүсвэр. Гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцох мэдээллийн эх үүсвэр нь “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг” /гаалийн мэдүүлэг/ болон захиргааны бусад мэдээлэл байна. Захиргааны мэдээлэлд Монголбанкны алтны арилжааны мэдээ, Гадаад харилцааны яамны дипломат төлөөлөгчийн газруудын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ зэрэг орно.
- 3.5. Гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцоход барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн огноог ашиглана.

#### **IV. Барааны урсгал**

- 4.1 Импортод худалдааны бүртгэлийн ерөнхий системийн дагуу дараах урсгал хамаарна. Үүнд:
- 4.1.1. гадаадын барааг хилийн чанадаас дотоодын хэрэглээнд оруулах;
  - 4.1.2. гадаадын барааг хилийн чанадаас оруулж, дахин боловсруулан дотоодын хэрэглээнд оруулах;
  - 4.1.3. хилийн чанадаас гадаадын барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулахаар 1 жилээс дээшгүй хугацаагаар оруулах;
  - 4.1.4. гадаадын барааг хилийн чанадаас гаалийн баталгаат агуулах, үйлдвэрийн газар, барилгын талбай, тусгай бүсэд оруулах;
  - 4.1.5. гадаадын барааг гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар болон татваргүй барааны дэлгүүрээс гаалийн нутаг дэвсгэрт оруулах;
  - 4.1.6. гадаадын барааг хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах;
  - 4.1.7. хилийн чанадад боловсруулахаар гаргасан монголын барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах;
  - 4.1.8. хилийн чанадад бүрмөсөн гаргасан монголын барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах.
- 4.2 Экспортод худалдааны бүртгэлийн ерөнхий системийн дагуу дараах урсгал хамаарна. Үүнд:
- 4.2.1 монголын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах;
  - 4.2.2 монголын барааг хилийн чанадад боловсруулахаар гаргах;

- 4.2.3 гадаадын барааг хилийн чанадад буцаан гаргах /гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд орсноос бусад гадаадын бараа, баталгаат бүсийн горимд байршуулсан гадаадын бараа/.

## **V. Гадаад худалдааны барааны статистикийн бүртгэлд хөтлөгдвэл зохих бараа**

### **5.1 Экспорт, импортод оруулж тооцвол зохих бараа:**

- 5.1.1 мөнгөжөөгүй алт;
- 5.1.2 гүйлгээнд ороогүй мөнгөн тэмдэгт, зоос, үнэт цаас;
- 5.1.3 Засгийн газрын худалдааны хэлэлцээр, гадаад тусlamжийн хөтөлбөр болон дайны нөхөн төлбөрийн дагуу эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж, түүнээс гаргаж байгаа иргэний болон цэргийн зориулалттай бараа /төлбөр, хандив, зээл, солилцооны бараа хамаарна/;
- 5.1.4 хүмүүнлэгийн болон буцалтгүй тусlamжийн бараа;
- 5.1.5 хөрөнгө оруулалтын бараа;
- 5.1.6 цэргийн зориулалттай бараа;
- 5.1.7 зорчигчийн арилжааны шинж чанартай бараа;
- 5.1.8 консигнацийн бараа /улсын хил нэвтрэх үед өмчлөлийн эрх шилжээгүй, арилжих зорилго бүхий бараа, тухайлбал үзэсгэлэн, яармагт тавигдаж буй бараа/;
- 5.1.9 арилжааны зориулалттай програм хангамж, бичлэг хийгдсэн аудио, видео хальс;
- 5.1.10 толгой компани болон түүний шууд хөрөнгө оруулалтаар бий болсон охин компаний хооронд шилжүүлж буй бараа;
- 5.1.11 цахилгаан эрчим хүч, хий, ус;
- 5.1.12 улс хоорондын шуудан илгээмжийн арилжааны шинж чанартай бараа;
- 5.1.13 шилжин суурьшигчдын үнэ бүхий эд хогшил;
- 5.1.14 нэг ба түүнээс дээш жилээр түрээслэх бараа;
- 5.1.15 хоосон лонх, сав, баглаа, боодол;

- 5.1.16 тодорхой үнэ өртөг бүхий үйлдвэрлэлийн хаягдал, үлдэгдэл /тухайлбал, хаягдал лааз, хүнсний үйлдвэрлэлээс гарсан үлдэгдэл, хаягдал зэрэг/, аюултай хог хаягдал;
- 5.1.17 усан онгоц, агаарын болон бусад тээврийн хэрэгсэл;
- 5.1.18 Монгол улсын нутаг дэвсгэрт гадаадын нисэх онгоцонд олгосон түлш, шатахуун, хүнс болон бусад эд зүйл;
- 5.1.19 Монгол улсын нутаг дэвсгэрт гадаадын нисэх онгоцноос дотоодын нисэх онгоцонд олгосон түлш, шатахуун, хүнс, бусад эд зүйл болон гадаадын нисэх онгоцноос дотоодын нисэх буудалд буулгасан бараа.

## **5.2 Экспорт, импортын тооцоонд оруулахгүй бараа:**

- 5.2.1 мөнгөжсөн алт;
- 5.2.2 гүйлгээнд оруулсан мөнгөн дэвсгэрт, зоос, үнэт цаас /үүнд гадаад валютын зузаатгал орно/;
- 5.2.3 хилийн чанадад 1 жилээс дээшгүй хугацаагаар гаргасан, гаалийн нутаг дэвсгэрт 1 жилээс дээшгүй хугацаагаар оруулсан бараа;
- 5.2.4 улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа;
- 5.2.5 захиалгын сонин, тогтмол хэвлэл;
- 5.2.6 захиалгын дагуу хийгдсэн програм хангамж, түүнийг агуулж байгаа диск, эх бичлэг хийгдсэн аудио болон видео хальс; захиалгаар хийгдсэн зураг төсөл;
- 5.2.7 нэг жилээс дээшгүй хугацаагаар түрээслэх бараа;
- 5.2.8 устгах бараа;
- 5.2.9 дахин ашиглагдах эргэлтийн хоосон лонх, сав, баглаа, боодол;

## **5.3 Барааны экспорт, импортоод тооцогдохгүй, тусгайлан бүртгэх бараа:**

- 5.3.1. давагдашгүй хүчин зүйлийн улмаас гарсан хохирлыг арилгах, барилга байгууламж барих зэрэг тодорхой зорилгоор гаалийн нутаг дэвсгэрт 1 жилээс дээшгүй хугацаагаар нэвтрүүлсэн машин механизмыг дотоодын хэрэглээнд оруулах эсхүл хилийн чанадад гаргах тохиолдолд;
- 5.3.2. засварын зориулалттай бараа;

5.3.3. улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бараа.

## **VI. Барааны ангилал, хэмжих нэгж, улсын код**

- 6.1. Экспорт, импортыг барааны нэр төрлөөр гаргахад “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем” /БТКУС/-ийг ашиглана.
- 6.2. Барааны тоо хэмжээг дараах стандарт хэмжих нэгжээр илэрхийлнэ.  
Үүнд:

|                  |                     |                |
|------------------|---------------------|----------------|
| Хүндийн жин:     | килограмм           | кг             |
| Уртын хэмжүүр:   | метр                | м              |
| Талбайн хэмжүүр: | квадрат м           | м <sup>2</sup> |
| Эзэлхүүн:        | куб метр            | м <sup>3</sup> |
|                  | литр                | л              |
| Нэгж:            | ширхэг              | ш              |
|                  | хос                 | хос            |
|                  | 1000 ширхэг         | мян.ш          |
|                  | боодол              | боод.          |
| Хүчдэл:          | мянган киловатт цаг | мян.квт.цаг    |

- 6.3. Дэлхийн улс орнуудыг кодлохдоо НҮБ-аас боловсруулсан “Статистикт ашиглах улс болон бүс нутгийн стандарт код”-ыг баримтлана.

## **VII. Барааны үнэ, үнэлгээ**

- 7.1 Гадаад худалдааны барааны статистикт СИП, ДАФ үнийг ашиглана.
- 7.2 Импортын барааг СИП-Монгол улсын хилийн боомт нөхцөлийн үнээр бүртгэнэ. СИП нөхцөлийн үнэд барааны үнэ, Монгол улсын хил хүртэлх тээвэр, даатгалын зардал орно.
- 7.3 Экспортын барааг ДАФ-Монгол улсын хилийн боомт нөхцөлийн үнээр бүртгэнэ. ДАФ нөхцөлийн үнэд барааны үнэ, Монгол улсын хил хүртэлх тээвэр, даатгалын зардал орно.
- 7.4 Гүйлгээнд ороогүй мөнгөн тэмдэгт /төгрөгийн шинэ дэвсгэрт/, зоос, үнэт цаасыг СИП нөхцөлийн үнээр буюу захиалагчаас хэвлүүлэхээр төлсөн зардал дээр Монгол улсын хил хүртэлх тээвэрлэлт болон даатгалын зардлыг нэмсэн үнээр тооцно. Монголбанкнаас болон захиалагчаас гүйлгээнд ороогүй мөнгөн тэмдэгт, зоос, үнэт цаасны хэвлүүлсэн зардлын төлбөрийн баримтыг тухай бүр тодорхойлж, гаалийн байгууллагад мэдүүлсэн байна.
- 7.5 Гадаад худалдааны барааны үнийн дүнг мянган ам.доллараар илэрхийлнэ.

## **VIII. Худалдааны түнш орнууд**

- 8.1 Барааны гарал үүслийн улсыг импортын, барааг хүлээн авагч улсыг экспортын түнш орон гэж үзнэ.
- 8.2 Хилийн чанадад гаргасан монголын барааг өөрчлөлт оруулахгүй буцаан оруулах тохиолдолд тухайн барааг илгээгч улсыг гарал үүслийн орон гэж тодорхойлно.

## **IX . Мэдээллийг хэрэглэгчдэд тархаах**

- 9.1 Гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийг сар бүрийн 4-ний дотор, Үндэсний статистикийн хороо болон Гаалийн ерөнхий газрын хооронд байгуулсан гэрээний дагуу мэдээллийн санг улирлын дараа сарын 10-ны дотор Үндэсний статистикийн хороонд ирүүлсэн байна.
- 9.2 Гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийг хэвлэмэл эсхүл цахим хэлбэрээр хэрэглэгчдэд тархаана.
- 9.3 Гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийг хэрэглэгчдэд дараах хавсралтаар тархаана. Үүнд:

Хавсралт 1. Гадаад худалдааны нийт бараа эргэлт;

Хавсралт 2. Экспорт, импорт, орноор;

Хавсралт 3. Экспорт, импортын барааны хэмжээ /БТКУС-ийн барааны хэсгээр/;

Хавсралт 4. Экспортын зарим барааны хэмжээ, орноор;

Хавсралт 5. Импортын зарим барааны хэмжээ, орноор;

Хавсралт 6. Экспорт, орон болон бараагаар;

Хавсралт 7. Импорт, орон болон бараагаар;

Хавсралт 8. Экспорт, импортын барааны хэмжээ /БТКУС-ийн барааны бүлгээр/;

Хавсралт 9. Тусlamжийн барааны импорт, орон болон бараагаар;

Хавсралт 10. Зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа, орон болон бараагаар;

Хавсралт 11. Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, орон болон бараагаар;

Хавсралт 12. Тусlamжийн зарим барааны импорт, орноор;

Хавсралт 13. Зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа, орноор;

Хавсралт 14. Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, орноор;  
Хавсралт 15. Экспорт, импортын барааны тоо хэмжээ, үнийн  
өөрчлөлт;  
Хавсралт 16. Аргачлалын тайлбар.

- 9.4 Хавсралт 1-11, 16-г сар бүр, 12-14-ийг улирал бүр, хавсралт 15-ыг  
хагас жил, жилд тархаана.

-----oOo-----